

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 05 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

*2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр, Баасан гараг*

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 20
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	21 - 52
1.	<i>Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	22 - 23
2.	<i>Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	24 - 25
3.	<i>Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	25 - 45
4.	<i>“Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенц”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/</i>	45 - 52

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 05 дугаар сарын 24-ний өдөр  
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 57 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Баттөмөр, Б.Дэлгэрсайхан;

Чөлөөтэй: Н.Наранбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд;

Тасалсан: П.Анужин, Ж.Эрдэнэбат.

**Нэг.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, хошууч генерал С.Ганбямба, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал Ч.Гандирваа, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн дарга, хурандаа Г.Энхболд, Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга бөгөөд Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын дарга, цагдаагийн хурандаа О.Ганбат, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа Л.Нямдаваа, Цагдаагийн ерөнхий газрын Гадаад харилцаа, энхийг сахиулах ажиллагааны хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Эрдэнэдалай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, хошууч генерал С.Ганбямба, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн дарга, хурандаа Г.Энхболд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, бригадын генерал Л.Алтангэрэл, Төрийн тусгай хамгаалалтын газрын дэд дарга, хурандаа Д.Тэмүүлэн, Төрийн тусгай хамгаалалтын газрын Захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, хурандаа Х.Ууганбат, Төрийн тусгай хамгаалалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, хошууч Э.Ариунаа, Төрийн тусгай хамгаалалтын газрын Санхүүгийн хэлтсийн дарга, хошууч Ч.Бат-Очир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.*

## 1.ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31, 32, 33, 34, 35, 36, 37, 38, 39, 40, 41, 42, 43, 44, 45, 46, 47, 48, 49, 50, 51, 52, 53, 54, 55, 56, 57, 58, 59, 60 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31, 32, 33, 34, 35, 36, 37, 38, 39, 40, 41, 42, 43, 44, 45, 46, 47, 48, 49, 50, 51, 52, 53, 54, 55, 56, 57, 58, 59, 60 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ үг хэлэв.

*Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нараас гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

## Нэг.ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ БОЛОН ТҮҮНТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

**Б.Энх-Амгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ төсөл /цаашид “Төсөл” гэх/-ийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь төрийн тусгай хамгаалалтын хамрах хүрээ, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндэс, алба хаагчийн эрх зүйн байдлыг тогтооход оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн гарчиг, 6.1 дэх хэсэг, 6.1.5, 6.2.5 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “хүн”, “хүний”, “хүнийг” гэснийг тухай бүрд “иргэн”, “иргэний”, “иргэнийг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.6, 3.1.7 дахь заалтын “энэ хуульд заасны дагуу” гэснийг тус тус хасаж, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахаас сэргийлэх” гэснийг “үндсэн хуульт байгууллын аюулгүй байдлыг хангах” гэж өөрчилж, 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтын “айлчилж байгаа” гэсний дараа “болон Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч байгаа” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.6 дахь заалтыг доор дурдсанаар 6.2.6, 6.2.7 болгон өөрчлөн найруулах:

“6.2.6.энэ хуулийн 6.1.6-д заасан зочин айлчлах болон дамжин өнгөрөх хугацаанд;

6.2.7.энэ хуулийн 6.1.7-д заасан зочин айлчлах хугацаанд болон хүсэлт гаргавал Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх хугацаанд.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “Төрийн тусгай хамгаалалтын байгууллага” гэснийг хасаж, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “энэ хуульд” гэснийг “энэ хуулийн 7.2-т” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн “барилга байгууламж” гэснийг “барилга, бусад зүйл” гэж, мөн хэсгийн болон 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “маршрутын” гэснийг “чиглэлийн” гэж, 37 дугаар зүйлийн 37.1.10 дахь хэсгийн “маршрут” гэснийг “чиглэл” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “тохиолдолд” гэснийг “бол” гэж өөрчилж, 10 дугаар зүйлийн 10.4, 10.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.4.Олон улсын дээд хэмжээний уулзалт, хурлыг төрийн тусгай хамгаалалтад авахад шаардагдах зардлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

10.5.Төрийн тусгай хамгаалалтад зайлшгүй байх бусад зүйлийн жагсаалтыг төрийн тусгай хамгаалалтын зорилгод нийцүүлэн Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “байж болно” гэснийг “байна” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “бусад хүн” гэснийг “бусад этгээд” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “хүн” гэснийг “аливаа этгээд” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.2, 13.5 дахь хэсгийг нэгтгэж, 13.2 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.2.Хамгаалалтын дэглэмээр тодорхой эд зүйл нэвтрүүлэхийг хориглох, зорчих хөдөлгөөн болон тодорхой үйл ажиллагаа явуулахыг хязгаарлах, түр зогсоох, хяналтын дэг журам тогтоох зэрэг бусад үйл ажиллагааг явуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсэг болон 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийг нэгтгэж, 14.3 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.3.Энэ хуулийн 14.2-т заасан урьдчилан сэргийлэх, хамгаалалтын техникийн, орчны болон эрүүл ахуйн үзлэг хийх журам, зааврыг төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “олон улсын дээд хэмжээний” гэсний дараа “уулзалт,” гэж нэмж, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “хамгаалалт найдвартай байхад чиглэсэн” гэснийг “хамгаалалтын бусад” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “байгууламж,” “найдвартай” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “барилга байгууламжийг” гэснийг “барилгыг” гэж, 17.3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “барилга байгууламжийн” гэснийг “барилга, бусад зүйлийн” гэж, Гуравдугаар бүлгийн гарчгийн “ХҮЛЭЭХ ҮҮРЭГ” гэснийг “ТЭДГЭЭРИЙН

ЧИГ ҮҮРЭГ” гэж, 19, 20, 21, 22, 23, 24 дүгээр зүйлийн гарчгийн “үүрэг” гэснийг “чиг үүрэг” гэж, 32 дугаар зүйлийн гарчгийн “бүрэн эрх” гэснийг “хэрэгжүүлэх чиг үүрэг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**14.** Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“18.1.Төрийн тусгай хамгаалалтыг төрийн тусгай хамгаалалтын байгууллага хэрэгжүүлэх бөгөөд төрийн бусад байгууллага энэ хууль болон холбогдох хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд дэмжлэг үзүүлэн оролцоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**15.** Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “эрүүгийн” гэсний дараа “болон хэв журмын талаар” гэж нэмж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хүсэлтээр хамгаалуулагчийн ажиллаж, амьдарч байгаа орчин болон хүнсний бүтээгдэхүүнд эрүүл ахуйн хөндлөнгийн хяналт тавьж, лабораторийн шинжилгээ хийнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**16.** Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “ашгийн төлөө бус” гэснийг “төрийн бус” гэж, 24.2 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, ашгийн төлөө бус байгууллага” гэснийг “Энэ хуулийн 24.1-д заасан байгууллага, албан тушаалтан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагад мэдээлэл өгч, хамгаалалтын талаарх санал зөвлөгөөг тусгаж ажиллана” гэснийг “төрийн тусгай хамгаалалтын байгууллагад урьдчилан мэдээлэл өгч, хамгаалалтын талаарх санал, зөвлөгөөг тусгаж хамтран ажиллана.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

18. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “үзүүлж хамтран ажиллана” гэснийг “үзүүлэх үүрэг хүлээнэ” гэж өөрчилж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “хуульд заасан хүрээнд зохион байгуулж” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийг 28 дугаар зүйлтэй нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“27 дугаар зүйл. Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүрэг**

27.1. Төрийн тусгай хамгаалалтын байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

27.1.1. төрийн тусгай хамгаалалтыг зохиох, хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах;

27.1.2. төрийн тусгай хамгаалалтад авсан хурал, барилга, бусад зүйлийг хамгаалах;

27.1.3. хамгаалалтын иж бүрэн байх зарчимд нийцүүлэн төрийн тусгай үйлчилгээг үзүүлэх;

27.1.4. төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн бодлого, шийдвэр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах, төрийн тусгай хамгаалалтын хууль тогтоомжийн биелэлтийг хангах;

27.1.5. төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудыг төрийн тусгай хамгаалалтын чиглэлээр нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах, чиглүүлэх;

27.1.6.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл цуглуулах, холбогдох мэдээ, мэдээллээр шуурхай хангагдах, энэ хуульд заасан аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх;

27.1.7.энэ хуулийн 24.1-д заасан байгууллага, албан тушаалтан болон иргэнээс шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгаа гаргуулж авах;

27.1.8.чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан тусгай зориулалтын техник хэрэгсэл, мэдээллийн сантай байх, тэдгээртэй холбоотой засвар, үйлчилгээ, инженерийн дэд бүтцээр хангагдах;

27.1.9.хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор явган зорчигч, автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шаардлагатай тохиолдолд түр зогсоох, чиглэлийг өөрчлүүлэх;

27.1.10.энэ хуулийн 6.1.1-д заасан болон шаардлагатай тохиолдолд бусад хамгаалуулагчийг орон нутагт агаарын хөлөг, усан онгоц, галт тэргээр зорчин явах үед аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор уг тээврийн хэрэгслээр тухайн үед зорчих хүмүүс, тэдний ачаа тээшийг шалгахад, түүнчлэн хамгаалуулагчийг гадаадад явах үед хамт явах зорчигчдод Монгол Улсын нутаг дэвсгэрт гаалийн хяналт шалгалт хийхэд алба хаагчаа байлцуулах;

27.1.11.урьдчилсан хамгаалалт хэрэгжүүлэх, аюулгүй байдлын үзлэг хийх, хамгаалуулагчийн хэрэглэх хүнсний бүтээгдэхүүн болон бусад зүйлд лабораторийн шинжилгээ хийх, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагаас туслалцаа авах;

27.1.12.аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан төрийн тусгай хамгаалалтын бүсэд радио холбооны сүлжээ сарниулах, радио төхөөрөмжийн болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг түр зогсоох;

27.1.13.хамгаалуулагч болон төрийн тусгай хамгаалалтад байгаа барилга, бусад зүйл, тэдгээрийн орчинд эмх замбараагүй байдал үүсэх, гамшиг, гэнэтийн осол гарах зэргээр нөхцөл байдал хүндэрсэн үед болон шаардлагатай бусад тохиолдолд тагнуул, цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага болон зэвсэгт хүчин, хилийн цэргээс дэмжлэг авах, харилцан хамтран ажиллах;

27.1.14.төрийн байгууллагын төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээллийн санд нэвтрэх, албаны хэрэгцээнд ашиглах;

27.1.15.төрийн тусгай хамгаалалтыг далд хэлбэрээр хэрэгжүүлэхдээ өөр байгууллагын баримт бичиг, албаны дүрэмт хувцас болон бусад зүйлийг ашиглах;

27.1.16.тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио хэрэглэх;

27.1.17.гадаад улсын төрийн хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;

27.1.18.аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнд хүсэлт, шаардлага тавих;

27.1.19.энэ хуулийн 6.1.1-д заасан хамгаалуулагчийг өргөө, зориулалтын орон сууц, үйлчлэх бүрэлдэхүүн, эдийн болон хүнсний бүтээгдэхүүнээр хангах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, өргөө, зориулалтын орон сууцны ашиглалтын техникийн бэлэн байдлыг хариуцах;

27.1.20.хамгаалуулагчид зориулалтын тээврийн хэрэгсэл, тусгай холбоогоор үйлчлэх;

27.1.21.төрийн тусгай хамгаалалтын бүс, түүний орчинд холбогдох байгууллагуудтай хамтран инженер-техникийн үзлэг, шалгалт хийж аюулгүй байдлыг хангах;

27.1.22.төрийн тусгай хамгаалалтын бүсэд хамгаалалтын дэглэм сахиулах, халдлага, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээ авах;

27.1.23.чиг үүргийнхээ хүрээнд террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох;

27.1.24.үйл ажиллагаандаа шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг ашиглах, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн болон бусад хяналтын систем нэвтрүүлэх;

27.1.25.хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай өөрт нь мэдээлж, танилцуулах;

27.1.26.байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

27.1.27.хуульд заасан бусад гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн “хүн, хуулийн этгээд” гэснийг “бусад этгээд” гэж өөрчилж, 32 дугаар зүйлийн “төрийн тусгай хамгаалалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;” гэсэн 32.1.2 дахь заалт, “энэ хуулийн 12.1.2-т заасан зөвшөөрөл олгох;” гэсэн 32.1.5 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалтын “биелэлтийг хангуулах” гэснийг “мөрдүүлэх” гэж, 32.1.10 дахь заалтын “мэдлэг чадварыг” гэснийг “мэдлэг, ур чадварыг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 32.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.1.7.төрийн тусгай хамгаалалтын байгууллагыг дотоод, гадаадад төлөөлөх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 6

Бүгд: 11

45.5 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Б.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Б.Энх-Амгалан:** Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22. Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “Энэ хуульд заасан” гэснийг “Төрийн тусгай

хамгаалалтын алба хаагчийн” гэж, “албан хаагч байна” гэснийг “албан хаагч мөн” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 33.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“33.4.Шадар хамгаалалтын ажилтан нь төрийн тусгай хамгаалалтын чиглэлээр гурваас доошгүй жил ажилласан, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**23.** Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.7 дахь хэсгийн “алба хаагч нь байгууллагаас олгосон албаны үнэмлэхтэй байх ба” гэснийг хасаж, 35.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“35.8.Аливаа этгээд төрийн тусгай хамгаалалтын албаны дүрэмт хувцас, үнэмлэхийг хэрэглэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**24.** Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн “энэ хуульд” гэснийг “энэ хуулийн 33.2-г” гэж, 37 дугаар зүйлийн 37.1.3 дахь заалтын “энэ хуульд заасны дагуу” гэснийг “энэ хуулийн 11.4-г заасан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**25.** Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.3.Алба хаах насны дээд хязгаарт хүрсэн төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн алба хаах хугацааг түүний хүсэлтийг үндэслэн мэдлэг, ур чадвар, туршлага, эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**26.** Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалтын “холбоотой” гэсний дараа “хууль ёсны” гэж, мөн зүйлийн 37.1.6 дахь заалтын “эд зүйлд” гэсний өмнө “бие болон” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**27.** Төслийн 38 дугаар зүйлийн 38.1.1 болон 38.1.7 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.1.1.өргөсөн тангарагтаа үнэнч байж, төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**28.** Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.1.4 дэх заалтын “явахгүй” гэсний, 39 дүгээр зүйлийн 39.1.2 дахь заалтын “тавихгүй” гэсний дараа “байх” гэж тус тус нэмж, 38 дугаар зүйлийн 38.1.8 дахь заалтыг 38.1.7 болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.1.7.өөрийн бие бялдар, эрүүл мэнд, мэргэжил, мэргэшил, албаны бэлтгэлийн түвшинг хадгалах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**29.** Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.1.10 дахь заалтын “холбогдон” гэснийг хасаж, 39 дүгээр зүйлийн 39.1.7 дахь заалтын “холбогдох хууль тогтоомжид” гэснийг “хуульд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**30.** Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийг хасаж, 42 дугаар зүйлийн 42.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“42.8.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч ажилдаа ирэх, буцах замд явах болон энхийг дэмжих ажиллагаанд оролцохыг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нэгэн адил тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**31.** Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “гэмт халдлагын улмаас” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

## **Хоёр.ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ОРДНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Б.Энх-Амгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 7.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.3.Төрийн ордон нь төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах холбоо, аюулгүй байдлыг хангах тусгай техник хэрэгслээр тоноглогдсон байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**2.** Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 7.7 дахь хэсгийг нэмэх:

“7.7.Төрийн ордны хамгаалалтыг хариуцсан нэгж энэ хуулийн 3.2-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлаас тогтоосон нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хариуцна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**3.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 7.8 дахь хэсгийн “дарга болон дотоодын цэргийн командлагчийн” гэснийг “даргын” гэж өөрчилж, 3 дугаар зүйлийн 9.2 дахь хэсгийн “үйлчилгээ явуулах болон засвар” гэсний өмнө “ордонд” гэж, “үйлчилгээний тусгай” гэсний өмнө “ордны” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.**

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

### **Гурав.ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Б.Энх-Амгалан: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.**

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

**Б.Энх-Амгалан: “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.**

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн төсөлд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хууль, тогтоолын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

## 2.ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

## 3.ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

## 4.ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

## 5.ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

## 6.РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

#### 7.ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

#### 8.ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

#### 9.ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

#### 10.МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

#### 11.СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

## 12.МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ОРДНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

## 13.ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв. “Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенц”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, мөн газрын ахлах мэргэжилтэн Б.Энхбат, мэргэжилтэн Н.Эрдэнэ, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал С.Сүхболд, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чимэдсүрэн, Татварын ерөнхий газрын Олон улсын татварын хэлтсийн дарга Л.Мөнхтуул оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ж.Түвшинжаргал, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн тавьсан асуултад Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал С.Сүхболд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар үг хэлэв.

**Б.Энх-Амгалан:** “Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенц”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 19 минут үргэлжилж, 17 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 64.7 хувийн ирцтэйгээр 12 цаг 16 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордны “Их засаг” танхим  
10 цаг 57 минут

### БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Б.Энх-Амгалан:** Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Бямбасүрэнгийн Энх-Амгалан ирсэн, Норовын Алтанхуяг ирсэн, Ганибалын Амартүвшин ирсэн, Хавдисламын Баделхан ирсэн, Баагаагийн Батгөмөр томилолттой, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ чөлөөтэй, Сүхбаатарын Батболд өвчтэй, Дашдондогийн Ганбат гишүүн ирсэн, Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн орон нутагт томилолттой, Нанзадын Наранбаатар гишүүн чөлөөтэй, Салдангийн Одонтуяа гишүүн ирсэн, Цэдэвийн Сэргэлэн гишүүн ирсэн, Дамдины Цогтбаатар гишүүн ирсэн, Нямаагийн Энхболд гишүүн ирсэн байна.

Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя.

**Нэгдүгээр асуудал.** Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд.

Засгийн газар 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг.

**Хоёрдугаар асуудал.** Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд.

Засгийн газар 2024 оны 04 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлэг.

**Гуравдугаар асуудал.** Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд.

Засгийн газар 2024 оны 05 сарын 03-ны өдөр өргөн мэдүүлсэн. Анхны хэлэлцүүлэг.

**Дөрөв дэх асуудал.** Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл.

Засгийн газар 2024 оны 05 сарын 03-ны өдөр өргөн мэдүүлсэн. Соёрхон батлах.

Эдгээр 4 асуудлыг өнөөдөр хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа орёё.

**Нэг.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулья.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулья.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Гүрсэдийн Сайханбаяр, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Дагвадоржийн Ганхуяг, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, хошууч генерал Сүнрэвийн Ганбямба, Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Хуулийн хэлтсийн дарга, хурандаа Гомбосүрэнгийн Энхболд, Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга бөгөөд Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын дарга, цагдаагийн хурандаа Одоохүүгийн Ганбат, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа Лхамдоржийн Нямдаваа, Цагдаагийн ерөнхий газрын Гадаад харилцаа, энхийг сахиулах ажиллагааны хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Байгалийн Эрдэнэдалай нар оролцож байна.

Батлан хамгаалах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал Ч.Гандирваа ирсэн байна.

Эдгээр бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна.

Байнгын хорооноос нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудыг энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн холбогдох хэсэг, заалтад тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцэхэд бэлтгэсэн тухай танилцуулгыг Байнгын хорооны гишүүдэд урьдчилан тараасан болно.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан танилцуулна.

Танилцуулья. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн

төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулга.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 04 сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлсэн.

Байнгын хорооноос нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудыг Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн холбогдох хэсэг, заалтад нэмж тусгаснаас гадна төслийн агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, хууль зүйн техникийн талаас нь хянаж, зохих засвар өөрчлөлтийг хийсэн эцсийн хувилбарыг Та бүхэнд тараасан болно.

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт

оруулах тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэгдсэн талаарх танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлүүлэхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Танилцуулгыг хийж дууслаа.

Хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү. Алга байна. /алх цохив/

Төслийн танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд миний бие танилцуулна.

Дараагийн асуудалдаа орёе.

**Хоёр.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Түрүүний миний дурдсан албан тушаалтнууд энд хуралдаанд оролцож байна.

Байнгын хорооноос нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудыг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийн холбогдох хэсэг, заалтад нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг бэлтгэсэн тухай танилцуулгыг Байнгын хорооны гишүүдэд урьдчилан тараасан болно.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан танилцуулна.

Танилцуулъя. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулга.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 04 сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлсэн болно.

Байнгын хорооноос нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудыг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн холбогдох хэсэг, заалтад нэмж тусгаснаас гадна төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, хууль зүйн техникийн талаас нь хянаж, зохих засвар өөрчлөлтийг хийсэн эцсийн хувилбарыг Та бүхэнд тараасан болно.

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулахтай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү. Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн танилцуулна.

Хэлэлцэж дууслаа. Ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Дараагийн асуудалдаа орёе.

---

**Гурав.Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд**  
/Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн,  
анхны хэлэлцүүлэг/

---

Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль Шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай

хуульд өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга, бригадын генерал Лхамсүрэнгийн Алтангэрэл, Төрийн тусгай хамгаалалтын газрын дэд дарга, хурандаа Долгорсүрэнгийн Тэмүүлэн, Төрийн тусгай хамгаалалтын газрын Захиргааны удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, хурандаа Хурцын Ууганбат, Төрийн тусгай хамгаалалтын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга, хошууч Эрдэнэдашийн Ариунаа, Төрийн тусгай хамгаалалтын газрын Санхүүгийн хэлтсийн дарга, хошууч Чойжамцын Бат-Очир.

Эдгээр хүмүүс хуралдаанд оролцохоор ирсэн байна. Хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудаа танилцуулж дууслаа. /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хуралдаантай холбогдуулаад Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 04 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү.

Б.Бат-Эрдэнэ гишүүн. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

**Б.Бат-Эрдэнэ:** Та бүхнийхээ өнөөдрийн амгаланг айлтгая.

Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа.

Би энэ төрийн тусгай хамгаалалтыг удирдаж байгаа хүмүүст хандаж хэлэх гээд байгаа юм.

Энэ ажилд авч байгаа хүмүүсээ давтан сургахтай холбоотой энэ харьцаа, хандлага. Энэ чинь цэргийн байгууллага шүү дээ. Тийм ээ.

Тэгээд тусгай чиг үүрэг гүйцэтгэж байгаа байгууллага.

Энэ хүмүүс дээр нэлээн анхаарал тавимаар байна. Ингэхгүй бол болохгүй юм.

Тэгээд энэ хүмүүсийн орж гарах нь их байдаг юм уу? Тэгээд л энгийн хувцастай, дагалдан бололтой хэдэн хүүхдүүд зогсож байгаад л тэгээд л төд удалгүй цэргийн цол форм өмсөөд л харуул хамгаалалт, янз бүрийн энэ үйл үйл ажиллагаа явуулах юм.

Тэгээд тэр хүмүүсийн байдал дээр.

Тэгээд би заримаас нь асуудаг юм. Хүү минь хаана, юу хийж байсан, ямар юутай гээд. Ихэнх нь цэргийн алба хаасан л гэж хэлээд байгаа юм.

Тэгээд энэ юман дээрээ жаахан анхаарахгүй бол болохгүй байна. Энэ чинь төрийн нэр хүндийн асуудал шүү.

Бид Улсын Их Хурлын түвшинд шатны гишгүүрийг дээрээс нь шүүрдэнэ гээд, Их Хурлаасаа хэлнэ ээ гээд Их Хурлын гишүүний хууль, дүрэм, энэ хариуцлага, ёс зүй, сахилга энэ бүх юмтай холбоотой.

Ашиг сонирхлоос ангид байх энэ бүх юмыг нь шаардаад шахаад ингээд цэгцлээд явдаг.

Гэтэл Төрийн энэ тусгай хамгаалалтын газрын албан хаагчдын сахилга, ёс зүй, харьцаа хандлага энэ бол их чухал ийм зүйл шүү.

Тийм учраас энэ дээр одоо бүр онцгойлон анхаарал тавих хэрэгтэй байна.

Зөвхөн энэ харуул хамгаалалтад ажиллаж байгаа төдийгүй энэ төрийн гурван өндөрлөгийн комиссарууд байна шүү дээ.

Энэ хүмүүс дээр бүр онцгойлон анхаарахгүй л бол болохгүй шүү.

Ийм зүйлийг л би Та бүхэнд зориуд анхааруулж хэлэх гээд байгаа юм.

**Б.Энх-Амгалан:** Санал хэлчихлээ. Анхааралдаа аваарай. Протоколд тэмдэглээрэй.

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 16 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 17 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 18 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 19 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 20 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 22 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 23 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 24 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 25 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 26 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 27 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 28 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 29 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 30 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 31 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 32 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 33 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 34 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 35 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 36 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 37 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 38 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 39 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 40 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 41 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 42 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 43 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 44 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 45 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 46 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 47 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 48 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн хуулийн төслийн 49 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 50 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 51 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 52 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 53 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 54 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 55 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 56 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 57 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 58 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 59 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 60 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан, Нямаагийн Энхболд нар зарчмын

зөрүүтэй саналын томъёолол бэлтгэж ирүүлсэн.

Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол тус бүрээр санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ төсөл /цаашид “Төсөл” гэх/-ийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь төрийн тусгай хамгаалалтын хамрах хүрээ, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндэс, алба хаагчийн эрх зүйн байдлыг тогтооход оршино.”

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 дэмжиж, 63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн гарчиг, 6.1 дэх хэсэг, 6.1.5, 6.2.5 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “хүн”, “хүний”, “хүнийг” гэснийг тухай бүрд “иргэн”, “иргэний”, “иргэнийг” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Бямбасүрэнгийн Энх-Амгалан, Нямаагийн Энхбол. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.6, 3.1.7 дахь заалтын “энэ хуульд заасны дагуу” гэснийг тус тус хасаж, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахаас сэргийлэх” гэснийг “үндсэн хуульт байгууллын аюулгүй байдлыг хангах” гэж өөрчилж, 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтын “айлчилж байгаа” гэсний дараа “болон Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч байгаа” гэж нэмэх.

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

4.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.6 дахь заалтыг доор дурдсанаар 6.2.6, 6.2.7 болгон өөрчлөн найруулах:

“6.2.6.энэ хуулийн 6.1.6-д заасан зочин айлчлах болон дамжин өнгөрөх хугацаанд;

6.2.7.энэ хуулийн 6.1.7-д заасан зочин айлчлах хугацаанд болон хүсэлт гаргавал Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх хугацаанд.”

Санал гаргасан Бямбасүрэнгийн Энх-Амгалан, Нямаагийн Энхбол. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

5.Төслийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “Төрийн тусгай хамгаалалтын байгууллага” гэснийг хасаж, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн

“энэ хуульд” гэснийг “энэ хуулийн 7.2-т” гэж өөрчлөх.

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 72.7 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

6.Төслийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн “барилга байгууламж” гэснийг “барилга, бусад зүйл” гэж, мөн хэсгийн болон 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “маршрутын” гэснийг “чиглэлийн” гэж, 37 дугаар зүйлийн 37.1.10 дахь хэсгийн “маршрут” гэснийг “чиглэл” гэж тус тус өөрчлөх.

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

7.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “тохиолдолд” гэснийг “бол” гэж өөрчилж, 10 дугаар зүйлийн 10.4, 10.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.4.Олон улсын дээд хэмжээний уулзалт, хурлыг төрийн тусгай хамгаалалтад авахад шаардагдах зардлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

10.5.Төрийн тусгай хамгаалалтад зайлшгүй байх бусад зүйлийн жагсаалтыг төрийн тусгай хамгаалалтын зорилгод нийцүүлэн Засгийн газар батална.”

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**8.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2** дахь хэсгийн “байж болно” гэснийг “байна” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтын “бусад хүн” гэснийг “бусад этгээд” гэж, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “хүн” гэснийг “аливаа этгээд” гэж тус тус өөрчлөх.

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**9.Төслийн 13 дугаар зүйлийн 13.2, 13.5** дахь хэсгийг нэгтгэж, 13.2 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.2.Хамгаалалтын дэглэмээр тодорхой эд зүйл нэвтрүүлэхийг хориглох, зорчих хөдөлгөөн болон тодорхой үйл ажиллагаа явуулахыг хязгаарлах, түр зогсоох, хяналтын дэг журам тогтоох зэрэг бусад үйл ажиллагааг явуулж болно.”

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**10.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4** дэх хэсэг болон 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийг нэгтгэж, 14.3 дахь хэсэг болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14.3.Энэ хуулийн 14.2-т заасан урьдчилан сэргийлэх, хамгаалалтын техникийн, орчны болон эрүүл ахуйн үзлэг хийх журам, зааврыг төрийн тусгай

хамгаалалтын байгууллагын дарга батална.”

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**11.Төслийн 15 дугаар зүйлийн 15.1** дэх хэсгийн “олон улсын дээд хэмжээний” гэсний дараа “уулзалт,” гэж нэмж, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “хамгаалалт найдвартай байхад чиглэсэн” гэснийг “хамгаалалтын бусад” гэж өөрчлөх.

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**12.Төслийн 17 дугаар зүйлийн 17.2** дахь хэсгийн “байгууламж,” “найдвартай” гэснийг тус тус хасах.

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**13.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1** дэх хэсгийн “барилга байгууламжийг” гэснийг “барилгыг” гэж, 17.3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “барилга байгууламжийн” гэснийг “барилга, бусад зүйлийн” гэж, Гуравдугаар бүлгийн гарчгийн “ХҮЛЭЭХ ҮҮРЭГ” гэснийг “ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ” гэж, 19, 20, 21, 22, 23, 24 дүгээр зүйлийн гарчгийн “үүрэг” гэснийг “чиг үүрэг” гэж, 32 дугаар зүйлийн гарчгийн “бүрэн эрх”

гэснийг “хэрэгжүүлэх чиг үүрэг” гэж тус тус өөрчлөх.

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**14.Төслийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.2 дахь хэсгийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“18.1.Төрийн тусгай хамгаалалтыг төрийн тусгай хамгаалалтын байгууллага хэрэгжүүлэх бөгөөд төрийн бусад байгууллага энэ хууль болон холбогдох хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд дэмжлэг үзүүлэн оролцоно.”

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**15.Төслийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “эрүүгийн” гэсний дараа “болон хэв журмын талаар” гэж нэмж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“23.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хүсэлтээр хамгаалуулагчийн ажиллаж, амьдарч байгаа орчин болон хүнсний бүтээгдэхүүнд эрүүл ахуйн хөндлөнгийн хяналт тавьж, лабораторийн шинжилгээ хийнэ.”

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**16.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “ашгийн төлөө бус” гэснийг “төрийн бус” гэж, 24.2 дахь хэсгийн “Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, ашгийн төлөө бус байгууллага” гэснийг “Энэ хуулийн 24.1-д заасан байгууллага, албан тушаалтан” гэж тус тус өөрчлөх.**

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**17.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “Төрийн тусгай хамгаалалтын байгууллагад мэдээлэл өгч, хамгаалалтын талаарх санал зөвлөгөөг тусгаж ажиллана” гэснийг “төрийн тусгай хамгаалалтын байгууллагад урьдчилан мэдээлэл өгч, хамгаалалтын талаарх санал, зөвлөгөөг тусгаж хамтран ажиллана” гэж өөрчлөх.**

Санал хураалт. /алх цохив/

63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**18.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “үзүүлж хамтран ажиллана” гэснийг “үзүүлэх үүрэг хүлээнэ” гэж өөрчилж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “хуульд заасан хүрээнд зохион байгуулж” гэснийг хасах.**

Санал хураалт. /алх цохив/

63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

19.Төслийн 27 дугаар зүйлийг 28 дугаар зүйлтэй нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“27 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын чиг үүрэг**

27.1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

27.1.1.төрийн тусгай хамгаалалтыг зохиох, хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах;

27.1.2.төрийн тусгай хамгаалалтад авсан хурал, барилга, бусад зүйлийг хамгаалах;

27.1.3.хамгаалалтын иж бүрэн байх зарчимд нийцүүлэн төрийн тусгай үйлчилгээг үзүүлэх;

27.1.4.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн бодлого, шийдвэр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах, төрийн тусгай хамгаалалтын хууль тогтоомжийн биелэлтийг хангах;

27.1.5.төрийн тусгай хамгаалалтад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудыг төрийн тусгай хамгаалалтын чиглэлээр нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах, чиглүүлэх;

27.1.6.төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл цуглуулах, холбогдох мэдээ, мэдээллээр шуурхай хангагдах, энэ хуульд заасан аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх;

27.1.7.энэ хуулийн 24.1-д заасан байгууллага, албан тушаалтан болон иргэнээс шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгаа гаргуулж авах;

27.1.8.чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан тусгай зориулалтын техник хэрэгсэл, мэдээллийн сантай байх, тэдгээртэй холбоотой засвар, үйлчилгээ, инженерийн дэд бүтцээр хангагдах;

27.1.9.хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор явган зорчигч, автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шаардлагатай тохиолдолд түр зогсоох, чиглэлийг өөрчлүүлэх;

27.1.10.энэ хуулийн 6.1.1-д заасан болон шаардлагатай тохиолдолд бусад хамгаалуулагчийг орон нутагт агаарын хөлөг, усан онгоц, галт тэргээр зорчин явах үед аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор уг тээврийн хэрэгслээр тухайн үед зорчих хүмүүс, тэдний ачаа тээшийг шалгахад, түүнчлэн хамгаалуулагчийг гадаадад явах үед хамт явах зорчигчдод Монгол Улсын нутаг дэвсгэрт гаалийн хяналт шалгалт хийхэд алба хаагчаа байлцуулах;

27.1.11.урьдчилсан хамгаалалт хэрэгжүүлэх, аюулгүй байдлын үзлэг хийх, хамгаалуулагчийн хэрэглэх хүнсний бүтээгдэхүүн болон бусад зүйлд лабораторийн шинжилгээ хийх, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн байгууллагаас туслалцаа авах;

27.1.12.аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан төрийн тусгай хамгаалалтын бүсэд радио холбооны сүлжээ сарниулах, радио төхөөрөмжийн болон бусад шаардлагатай тоног

төхөөрөмжийн үйл ажиллагааг түр зогсоох;

27.1.13.хамгаалуулагч болон төрийн тусгай хамгаалалтад байгаа барилга, бусад зүйл, тэдгээрийн орчинд эмх замбараагүй байдал үүсэх, гамшиг, гэнэтийн осол гарах зэргээр нөхцөл байдал хүндэрсэн үед болон шаардлагатай бусад тохиолдолд тагнуул, цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага болон зэвсэгт хүчин, хилийн цэргээс дэмжлэг авах, харилцан хамтран ажиллах;

27.1.14.төрийн байгууллагын төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээллийн санд нэвтрэх, албаны хэрэгцээнд ашиглах;

27.1.15.төрийн тусгай хамгаалалтыг далд хэлбэрээр хэрэгжүүлэхдээ өөр байгууллагын баримт бичиг, албаны дүрэмт хувцас болон бусад зүйлийг ашиглах;

27.1.16.тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрэл дохио хэрэглэх;

27.1.17.гадаад улсын төрийн хамгаалалтын байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;

27.1.18.аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэнд хүсэлт, шаардлага тавих;

27.1.19.энэ хуулийн 6.1.1-д заасан хамгаалуулагчийг өргөө, зориулалтын орон сууц, үйлчлэх бүрэлдэхүүн, эдийн болон хүнсний бүтээгдэхүүнээр хангах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, өргөө, зориулалтын

орон сууцны ашиглалтын техникийн бэлэн байдлыг хариуцах;

27.1.20.хамгаалуулагчид зориулалтын тээврийн хэрэгсэл, тусгай холбоогоор үйлчлэх;

27.1.21.төрийн тусгай хамгаалалтын бүс, түүний орчинд холбогдох байгууллагуудтай хамтран инженер-техникийн үзлэг, шалгалт хийж аюулгүй байдлыг хангах;

27.1.22.төрийн тусгай хамгаалалтын бүсэд хамгаалалтын дэглэм сахиулах, халдлага, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээ авах;

27.1.23.чиг үүргийнхээ хүрээнд террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох;

27.1.24.үйл ажиллагаандаа шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг ашиглах, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн болон бусад хяналтын систем нэвтрүүлэх;

27.1.25.хамгаалуулагчийн аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоор хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай өөрт нь мэдээлж, танилцуулах;

27.1.26.байгууллага, алба хаагчийн аюулгүй байдлыг хангах, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

27.1.27.хуульд заасан бусад.

Энэ дээр хоёр юм анхаараарай.

Нэг нь, төрийн тусгай хамгаалалтын бүс, түүний орчинд холбогдох байгууллагатай хамтран инженер, техникийн үзлэг шалгалт гэж аюулгүй байдлыг хангана гэж байгаа юм.

Энэ бол та нар төрийн энэ хамгаалалтын бүс дотор тагнах, чагнах хэрэгсэл тавих ойлголт биш шүү.

Үүнийг тэгж ойлгоорой.

Протоколдоо тэгж тэмдэглээрэй.

Тэгэхгүй тэгээд гишүүдийн өрөөнд янз янзын юм ингээд төрийн тусгай хамгаалалт хийх гэж байгаа юм гээд есөн шидийн ийм гүйцэтгэл ажлын юм явуулаад байвал энэ болохгүй гэдгийг би энд онцгой анхаарууллаа шүү.

Хууль санаачилж энд явуулж байгаа хүний хувьд.

Хоёр дахь нь, тэр төрийн байгууллагын төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээллийн санд нэвтрэх, албан хэрэгцээндээ ашиглах.

Тэр төрийн тусгай хамгаалалт нь далд хэлбэрээр хэрэгжүүлэхдээ өөр байгууллагын баримт бичиг, албаны дүрэмт хувцас хэрэглэх, ашиглах гэж.

Үүнийгээ та нар тагнуулын чиг үүргээр явуулав аа.

Татварын албаны үнэмлэх барьчихаад, тагнуулын байгууллагын үнэмлэх барьчихаад, эсвэл цагдаагийн байгууллагын үнэмлэх барьчихаад өөр чиг үүрэг хэрэгжүүлэв ээ.

Энд зөвхөн төрийн тусгай хамгаалалт буюу тэр хамгаалуулж байгаа хүнийхээ л эрх ашгийг хамгаалах ёстой шүү.

Үүнийг ингэж ойлгоорой. Ингэж протоколд тэмдэглээрэй.

Тэгэхгүй бол дараа нь үндсэн тагнуулынхаа байгууллагад баригддаггүй ингээд давхар тагнуулын байгууллагууд бий болоод бие биеийнхээ дотоод сүлжээг илрүүлээд яваад байх вий. За. Үүнийг анхаарна биз.

Санал хураалт. /алх цохив/

Протоколд сайн тэмдэглээрэй. Үүнийг.

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**20.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн “хүн, хуулийн этгээд” гэснийг “бусад этгээд” гэж өөрчилж, 32 дугаар зүйлийн “төрийн тусгай хамгаалалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;” гэсэн 32.1.2 дахь заалт, “энэ хуулийн 12.1.2-т заасан зөвшөөрөл олгох;” гэсэн 32.1.5 дахь заалтыг тус тус хасах.**

Санал хураалт. /алх цохив/

63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**21.Төслийн 32 дугаар зүйлийн 32.1.3 дахь заалтын “биелэлтийг хангуулах” гэснийг “мөрдүүлэх” гэж, 32.1.10 дахь заалтын “мэдлэг чадварыг” гэснийг “мэдлэг, ур чадварыг” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 32.1.7 дахь**

заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.1.7.төрийн тусгай хамгаалалтын байгууллагыг дотоод, гадаадад төлөөлөх;”

Санал хураалт. /алх цохив/

Д.Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

**Д.Цогтбаатар:** Байнгын хорооны дарга аа, би дэмжсэн санал өгсөн. Сая сөрөг гарчихлаа. Гацчихаад байна.

Тэгээд саяын санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү гэсэн горимын санал гаргаж байна.

**Б.Энх-Амгалан:** Д.Цогтбаатар гишүүний горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулья. Санал хураалт.

63.6 хувийн саналаар уг санал хураалт хүчингүй боллоо. Горимын санал дэмжигдлээ.

Дахин санал хураалт явуулья. Томьёоллыг түрүүн уншиж танилцуулсан. Санал хураалт. /алх цохив/

63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**22.Төслийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “Энэ хуульд заасан” гэснийг “Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн” гэж, “албан хаагч байна” гэснийг “албан хаагч мөн” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 33.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“33.4.Шадар хамгаалалтын ажилтан нь төрийн тусгай хамгаалалтын чиглэлээр гурваас доошгүй жил ажилласан, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байна.”

Санал хураалт. /алх цохив/

63.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**23.Төслийн 35 дугаар зүйлийн 35.7 дахь хэсгийн “алба хаагч нь байгууллагаас олгосон албаны үнэмлэхтэй байх ба” гэснийг хасаж, 35.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“35.8.Аливаа этгээд төрийн тусгай хамгаалалтын албаны дүрэмт хувцас, үнэмлэхийг хэрэглэхийг хориглоно.”

Санал хураалт. /алх цохив/

63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**24.Төслийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн “энэ хуульд” гэснийг “энэ хуулийн 33.2-т” гэж, 37 дугаар зүйлийн 37.1.3 дахь заалтын “энэ хуульд заасны дагуу” гэснийг “энэ хуулийн 11.4-т заасан” гэж тус тус өөрчлөх.**

Санал хураалт. /алх цохив/

63.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

**25.Төслийн 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“36.3.Алба хаах насны дээд хязгаарт хүрсэн төрийн тусгай

хамгаалалтын алба хаагчийн алба хаах хугацааг түүний хүсэлтийг үндэслэн мэдлэг, ур чадвар, туршлага, эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно.”

Санал хураалт. /алх цохив/

63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**26.Төслийн 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалтын “холбоотой” гэсний дараа “хууль ёсны” гэж, мөн зүйлийн 37.1.6 дахь заалтын “эд зүйлд” гэсний өмнө “бие болон” гэж тус тус нэмэх.**

63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ

**27.Төслийн 38 дугаар зүйлийн 38.1.1 болон 38.1.7 дахь заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“38.1.1.өргөсөн тангарагтаа үнэнч байж, төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэх;”

Санал хураалт. /алх цохив/

63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**28.Төслийн 38 дугаар зүйлийн 38.1.4 дэх заалтын “явахгүй” гэсний, 39 дүгээр зүйлийн 39.1.2 дахь заалтын “тавихгүй” гэсний дараа “байх” гэж тус тус нэмж, 38 дугаар зүйлийн 38.1.8 дахь заалтыг 38.1.7 болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“38.1.7.өөрийн бие бялдар, эрүүл мэнд, мэргэжил, мэргэшил, албаны бэлтгэлийн түвшинг хадгалах;”

Санал хураалт. /алх цохив/

63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**29.Төслийн 38 дугаар зүйлийн 38.1.10 дахь заалтын “холбогдон” гэснийг хасаж, 39 дүгээр зүйлийн 39.1.7 дахь заалтын “холбогдох хууль тогтоомжид” гэснийг “хуульд” гэж өөрчлөх.**

Санал хураалт. /алх цохив/

63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**30.Төслийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийг хасаж, 42 дугаар зүйлийн 42.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

“42.8.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч ажилдаа ирэх, буцах замд явах болон энхийг дэмжих ажиллагаанд оролцохыг албан үүргээ гүйцэтгэж байгаатай нэгэн адил тооцно.”

Санал хураалт. /алх цохив/

63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

**31.Төслийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “гэмт халдлагын улмаас” гэснийг хасах.**

Санал хураалт. /алх цохив/

54.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд.

1.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 7.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.3.Төрийн ордон нь төрийн тусгай хамгаалалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах холбоо, аюулгүй байдлыг хангах тусгай техник хэрэгслээр тоноглогдсон байна.”

Санал хураалт. /алх цохив/

Тусгай техник хэрэгсэл гэдэгт тагнах, чагнах PZIR<sub>[камер]</sub> энэ тэр орохгүй шүү. Үүнийг анхаараарай.

11 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 54.5 уг санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтад доор дурдсан агуулгатай 7.7 дахь хэсгийг нэмэх:

“7.7.Төрийн ордны хамгаалалтыг хариуцсан нэгж энэ хуулийн 3.2-т заасны дагуу Монгол Улсын Их Хурлаас тогтоосон нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хариуцна.”

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 7.8 дахь хэсгийн “дарга болон дотоодын цэргийн командлагчийн” гэснийг “даргын” гэж өөрчилж, 3 дугаар зүйлийн 9.2 дахь хэсгийн “үйлчилгээ явуулах болон засвар” гэсний өмнө “ордонд” гэж, “үйлчилгээний тусгай” гэсний өмнө “ордны” гэж тус тус нэмэх.

Санал хураалт. /алх цохив/

63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Н.Энхболд.

1.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах.

Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 54.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Нямаагийн Энхболд нарын гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Сүүлийн санал дэмжигдсэнтэй холбогдуулан “Хуулийн төсөл буцаах тухай” тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 05 сарын 03-ны өдөр Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд оролцох гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагч буцаасугай.

Тогтоолын төслийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 7 гишүүн дэмжиж, 63.6 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг буцаах тухай зарчмын зөрүүтэй саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.23-д заасны дагуу “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн томьёоллоор санал хурааж санал хураалтыг дүнг танилцуулж дууслаа. /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн төсөлд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Үүнтэй холбогдуулаад Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/ /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. /алх цохив/ /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн зүйлийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/ /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн

Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. /алх цохив/ /алх цохив/

Гүйцэтгэх ажлын тухай хуультай холбогдуулаад түрүүний миний хэлсэн зүйлүүдийг протоколд сайн тэмдэглэж, хуулийг яг тэгж ойлгож хэрэглэнэ шүү гэдгийг бас энд анхааруулья.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/ /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. /алх цохив/ /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Радио долгионы тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Радио долгионы тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Сонгуулийн автоматжуулсан системийн

тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн зүйл төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Н.Энхболд нарын зарчмын зөрүүтэй 4 саналын томъёолол бэлтгэж ирүүлсэн. Тэр саналын томъёоллоор санал хураалт явуулж дууссан болно.

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн төсөлд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэе.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байвал нэрээ өгнө үү? Алга байна. /алх цохив/

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. /алх цохив/

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрдэнэсийн сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Төрийн ордны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан танилцуулна.

Хуралдаанд оролцсон ажлын хэсгийнхэнд баярлалаа. Хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалдаа оръё. Одоо ганцхан асуудал үлдсэн.

---

**Дөрөв. “Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенц”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөл**  
/Засгийн газар 2024.05.03-ны өдөр өргөн мэдүүлсэн,  
**соёрхон батлах/**

---

Татварын суурийг багасгах тухай олон талт конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Засгийн газар 2024 оны 05 сарын 03-ны өдөр өргөн мэдүүлсэн. Соёрхон батлах.

“Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенц”-д нэгдэн орох тухай төслийг Засгийн газар 2022 оны 06 сарын 09-ний өдөр Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр ирүүлснийг Төсвийн байнгын хороо 2022 оны 06 сарын 13-ны өдөр хуралдаанаараа дэмжсэн байна.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дээрх конвенцыг зөвшилцөх асуудлыг 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж дэмжсэн бөгөөд хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хуралдааны тэмдэглэлийн хамт Засгийн газарт хүргүүлсэн болно.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулья.

Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Чимэдийн Хүрэлбаатар, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Сангийн яамны Татварын бодлогын газрын ахлах мэргэжилтэн Баасандоржийн Энхбат, Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Нямдаваагийн Эрдэнэ, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал С.Сүхболд. Татварын Ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Чойгүнсэнгийн Чимэдсүрэн, Татварын ерөнхий газрын Олон улсын татварын хэлтсийн дарга Лхагвасүрэнгийн Мөнхтуул нар хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнууд байна.

Албан тушаалтнуудыг танилцуулж дууслаа. /алх цохив/

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Шадар сайд Чимэдийн Хүрэлбаатар танилцуулна. Ч.Хүрэлбаатар сайдын микрофоныг өгье.

**Ч.Хүрэлбаатар:** Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнууд татвараас зайлсхийх, зугтах явдалтай тэмцэх, татварын суурийг хамгаалах чиглэлээр олон улсын хамтын ажиллагаа өргөжиж эрчимтэй хөгжиж байгаа билээ.

Тухайлбал, 2009 оны дэлхийн санхүүгийн хямралаас үүдэлтэйгээр “Их 7”-гийн санаачилгаар Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлын эсрэг **BEPS**<sub>[base erosion and profit shifting]</sub> ГЭХ олон улсын байгууллагыг байгуулсан.

Улмаар BEPS-ийн зүгээс татварын суурийг хамгаалах, ашиг шилжүүлэх явдлын эсрэг 15 үйл ажиллагааны багц дүрэм, журмыг боловсруулж танилцуулсан.

Одоогийн байдлаар 141 улс гишүүнээр нэгдэн ороод байна.

Монгол Улсын хувьд Европын Холбооны татварын зорилгоор хамтран ажилладаггүй улс орнуудын жагсаалтаас 2018 онд гарахдаа BEPS-ийн дүрэм журмуудын хэрэгжүүлэх үүрэг амлалт хүлээсэн.

Улмаар Монгол Улсын Засгийн газар 2018 оны 01 дүгээр сард BEPS-т 111 дэх гишүүнээр нэгдэн орж, BEPS-ийн холбогдох стандартуудыг 2019 оны татварын хуулийн шинэчлэлд тусган, хүлээсэн үүргээ биелүүлж ажилласнаар энэхүү жагсаалтаас гарсан.

Хэдийгээр Монгол Улс дотоодын хууль тогтоомжийг олон улсын шаардлагад нийцүүлэн шинэчилсэн хэдий ч 1991-2003 оны хооронд бусад улс орнуудтай байгуулсан 26 хоёр талт

давхар татварын гэрээнүүдийг BEPS-ийн 6, 14 дүгээр стандартад нийцүүлэх шаардлагатай байгаа юм.

Иймд Монгол Улсын давхар татварын гэрээнүүдийг BEPS-ийн стандартуудад нэг мөр нийцүүлэх зорилгоор Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенцыг соёрхон батлах нь зүйтэй байна.

Тус конвенцод нэгдэн орсноор татвараас зайлсхийн эсрэг ерөнхий дүрэм дүрмийг нэвтрүүлэх, төлөөний газар ногдол ашиг, хөрөнгийн татвартай холбоотойгоор давхар татварын гэрээ ашиглан татвараас зайлсхийх, эрсдэлийг бууруулах, харилцан тохиролцох үйл ажиллагааг идэвхжүүлэх зэрэг олон өөрчлөлтийг Монгол Улсын бусад улсуудтай байгуулсан 26 давхар татвар гэрээнд нэвтрүүлэх боломж бүрдэнэ.

Ингэснээр Монгол Улс давхар татварын гэрээнүүдийг урвуулан ашиглаж татвараас зайлсхийх, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх татварын суурийг хамгаалах чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Засгийн газраас боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенц”-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Б.Энх-Амгалан:** Ч.Хүрэлбаатар сайдад баярлалаа. Баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү?

Би асуулт асууна.

“Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор татварын гэрээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх тухай олон талт конвенц”-д нэгдэн орох тухай төслийг зөвшилцөх талаар Төсвийн байнгын хороо Аюулгүй байдлын байнгын хороонд 2022 оны 06 сарын 13-ны өдөр, 2022 оны 07 сарын 05-ны өдөр ирүүлжээ. Засгийн газраас.

Тэгээд одоо ороод ирэх болсон чинь энэ маань нэг баахан тодруулах асуудлуудтай болчихсон.

Тэрийг нь зөвшөөрнө, үүнийг нь зөвшөөрөхгүй, энд нь нэгдэнэ, энд нь нэгдэхгүй гээд нэг ийм нэг баахан заалтууд ороод ирчихсэн байдаг. Энэ ямар учиртай юм? Үүнийг надад нэг тайлбарлаач.

Энэ чинь уг нь Байнгын хороонд орж ирэхдээ олон улсын гэрээ конвенцод нэгдэхийг дэмжинэ, дэмжихгүй, Засгийн газарт эрх олгоно, олгохгүй гэдгээр л орж ирдэг шүү дээ.

Гэтэл Байнгын хороон дээр баахан тод тодруулах асуудал ороод ирчихсэн байх юм. Үүнийг нэг тайлбарлаадхаач. Хэн тайлбарлах вэ? 2 номерын микрофон. Өөрийгөө танилцуулаад тайлбарлаарай.

**Б.Тэлмүүн:** Байнгын хорооны даргын асуултад хариулъя.

Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн.

Энэ конвенц нь бол олон талт конвенц. Стандарт тексттэй.

Тухайн үед Засгийн газраас зөвшилцөхөөр өргөн мэдүүлэхдээ гэрээний зүйл, заалтыг эх хадгалагч талтай зөвшилцөөд оруулсан.

Конвенц нь өөрөө заавал сонголт хийх хэд хэдэн ийм хувилбаруудыг. Одоо жишээлэх юм бол татвараас зайлсхийх явдлаас урвуулан сэргийлэх дүрэм гэдэг нь өөрөө 3 төрлийн дүрэм байгаа. Энэ гэрээн дээр гурвууланг нь заачаад энэ дээр яг альныг нь сонголт хийх вэ гэдгээ элсэж орж байгаа улсууд нь тайлбараараа нэгдэж орох ийм асуудал байгаа.

Тэгэхээр зөвшилцөх үед энэ конвенцын эх текст болон тухайн үед илэрхийлж байсан байр сууриудыг бүгдийг нь илэрхийлж байсан. Тэр үеэс одоо өөрчлөгдсөн зүйл байхгүй байгаа.

Одоо яг хуулийн төсөл хэлбэртэй орж ирээд энэ асуудлууд нь илүү тодорхой ингэж орж ирж байгаа.

Тэгэхээр бид тухайн үед баримталж байсан байр суурь Засгийн газраар орж байсан. Мөн конвенцын эх хадгалагчтай харилцан зөвшилцсөн асуудлууд хэвээрээ байгаа. Баярлалаа.

**Б.Энх-Амгалан:** Тодруулах асуудалтай холбогдуулаад протоколд үлдэх зориулалтаар үүнийг бас хэлж өгье.

Та бүгдийн оруулж ирсэн зүйл дээр нэгдүгээрт төслийн 2 дугаар зүйлд Конвенцын 28 дугаар зүйлд л хамаарах 3 заалт, конвенцын 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт хамаарах 5 заалт туссан байна.

Конвенцын 28 дугаар зүйлийн оролцогч тал тайлбар хийх боломжтой бөгөөд уг 28 дугаар зүйлд заасны хүрээнд тайлбар хийхээр зохицуулсан.

Төслийн 2 дугаар зүйлийн 1, 2, 7 дугаар заалтууд нь конвенцын 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу энэ конвенцод зөвхөн дараах заалтууд тодорхойлсон тайлбар хийхийг зөвшөөрнө гэж заасны дагуу хийсэн тайлбар байна.

Харин төслийн 2 дугаар зүйлийн 3, 4, 5, 6, 8 дугаар заалтууд нь конвенцын 29 дүгээр зүйлд заасны дагуу гарын үсэг зурах үед, эсхүл соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсвэл баталсан тухай батламж бичгийг хадгалуулах үед мэдэгдэл хийх заалтууд байна.

Тодруулах асуудал нэг байна.

Олон улсын гэрээний тухай хуулийн 21.3 дахь хэсэгт олон талт олон улсын гэрээнд тайлбар хийх саналыг боловсруулахдаа тухайн олон улсын гэрээгээр тайлбар хийх боломжтой эсэх, тайлбар хийх боломжит хүрээ, тухайн олон улсын гэрээний бусад талын, эсхүл олон улсын байгууллагын зөвшөөрөл шаардлагатай эсэх зэрэг зохицуулалтыг харгалзана гэсэн заалттай нийцэж байгаа эсэх.

Конвенцын 29 дүгээр зүйлд заасны дагуу гарын үсэг зурах үед, эсхүл соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсвэл баталсан тухай батламж бичгийг

хадгалуулах үед мэдэгдэл хийхээр заасан заалтуудыг төсөлд тусгасан нь олон улсын гэрээний тухай хуулийн 21.3 дахь хэсгийн хүрээнд хэрхэн тайлбарлагдаж байгаа талаар тайлбар өгөөдөх.

Хэн өгөх вэ? 2 номер өгөх үү, эсвэл нэг номер өгөх үү? 1 номер. Гадаад харилцаан яам. Гэрээ, эрх зүйн газар тайлбар өгөөдөхье.

**С.Сүхболд:** Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан даргын асуултад хариулъя.

С.Сүхболд Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын захирал.

Олон улсын гэрээний тухай Венийн конвенц, олон улсын гэрээний тухай хуулийн заалтын дагуу энэ конвенцыг соёрхон батлахдаа аливаа тайлбар хийх зохицуулалтаар хуулийн зохицуулалтыг оруулж ирсэн.

Конвенцын 29 дүгээр зүйл дээр мэдэгдэл гэдэг зүйл заасан байгаа.

Гэхдээ одоогийн манай зохицуулалт бол олон улсын гэрээний конвенцоор тайлбар хийх буюу ямар нэгэн эрх үүрэг, хариуцлага хүлээх тохиолдолд сонголттой хийх боломжийг олгосон байдаг. Энэ хүрээндээ хуулийн төслийг оруулж ирсэн гэж үзэж байгаа.

**Б.Энх-Амгалан:** Нэг ёсондоо тайлбар хийж болно гэсэн үг юм байна. Тийм үү?

**С.Сүхболд:** Болно гэсэн үг. Тийм.

**Б.Энх-Амгалан:** Хоёр. Өргөн барьсан төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалтын дагуу Монгол Улс уг конвенцын 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийг өөрийн хамрагдах татварын гэрээнүүдэд хэрэглэхээр сонгохдоо уг конвенцын 7 дугаар зүйлийн 17 дахь хэсгийн “Б”, “Д” заалтуудыг үндэслэсэн байна.

Уг конвенцын 7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг бол гэрээний давуу тал эдлэх эрхтэй этгээдэд давуу талыг олгох эсэх зохицуулалт байна.

Уг конвенцын 7 дугаар зүйлийн 17 дахь хэсгийн “Б” заалт бол уг конвенцын 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг сонгосон оролцогч тал нь энэ тухайгаа хадгалагчид мэдэгдэх зохицуулалт байна.

Харин 7 дугаар зүйлийн 17 дугаар дахь хэсгийн “Д” заалт бол 7 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан давуу талыг хязгаарлах хялбаршуулсан зохицуулалт хэрэглэхгүйгээр 7 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “А”, эсхүл “Б” хэсгийн заалтыг сонгосон тухайгаа хадгалагчид мэдэгдэх зохицуулалт байна.

Тийм учраас эндээс тодруулах гээд байна.

Монгол Улс конвенцын 7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг өөрийн хамрагдах татварын гэрээнүүдэд хэрэглэхээр сонгохдоо хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 4 дэх заалтад ишилсэн 7 дугаар зүйлийн 17 дахь хэсгийн “Д” заалтын агуулгын хувьд нийцэж байгаа эсэх.

Уг конвенцын 7 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “А”, эсхүл “Б” хэсгийн Б заалтын аль нэгийг Монгол Улс хэрэглэхээр сонгох эсэх.

Уг конвенцын 7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 17 дахь хэсгийн “Д” заалттай агуулгын хувьд холбогдож байгаа эсэх талаар хариулт өгмөөр байна.

Татварын Ерөнхий газар өгөх үү? Хаанах өгөх вэ? 2 номер. Б.Тэлмүүн дарга.

**Б.Тэлмүүн:** Сангийн яам. Б.Тэлмүүн. Байнгын хорооны даргын асуултад хариулъя.

7 дугаар зүйл бол яг энэ гэрээний хамгийн чухал гол заалт.

Дээрээс нь Монгол Улс Европын Холбооны өмнө хүлээсэн үүргийн дагуу 7.4 гэсэн заалтыг бид хэрэглэх, заавал дагаж мөрдөх үүрэгтэй.

Энэ гэрээ өөрөө 7.4-өөсөө гадна таны дурдсан 7.7 болон бусад дэлгэрүүлсэн дүрмүүдийг хэрэглэх сонголт хийх боломжийг нэгдэж орж байгаа улсуудад хүлээлгэсэн байгаа.

Бидний хувьд 7-гийн давуу талыг хязгаарлах, хялбаршуулсан зохицуулалт хийх энэ нарийвчилсан хязгаарлалтын дүрмийг хэрэглэхгүй гэдгээр сонголтоо хийсэн.

Таны дурдсан заалтууд бол энэ хэрэглэхгүй гэж сонгож байгаа заалтуудыг бусад улс орнууд хэрэглэх тохиолдол манай улс яах вэ гэдэгтэй холбоотой зохицуулалт байгаа.

Одоогийн байдлаар бид нэгдүгээрт энэ заалтыг хялбаршуулсан зохицуулалтыг хэрэглэхгүй.

Хоёрдугаарт, манай улс энэ гэрээнд нэгдэж орсон бусад бүх талууд Монгол Улстай энэ гэрээний заалтыг хэрэглэхгүйгээр тайлбараа өгчихсөн байгаа.

Ирээдүйд гэрээний аль нэг тал болон Монгол Улс энэ хялбаршуулсан зохицуулалтыг хэрэглэх тохиолдолд 2 тал харилцан энэ дүрмийг яаж хэрэглэх тухай заалт нь таны дурдсан тэр Б гэдэг 2 заалт дээр байгаа.

Тэгэхээр бид одоо өргөн барьсан хуулийн 2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу явахад гэрээний зөрчил гарахгүй. Цаашдаа энэ гэрээг бусад улс орнууд хэрэглэх, нэмэлт тайлбар хийгээд явах боломжууд нь нээлттэй. Энэ тохиолдолд бид “А” юм уу, “Б” гэдэг заалтуудыг хэрэглээд явах бүрэн боломжтой гэж үзэж байгаа.

**Б.Энх-Амгалан:** Хариулт авлаа. Энэ дээр нэг зүйлийг анхаараарай та минь ээ.

Татварын суурийг багасгах тухай олон талт конвенцод нэгдэн орохдоо Монгол Улсын язгуур эрх ашгийг хамгийн түрүүнд тавих ёстой шүү.

Бид хамгийн боломжтой тэр хувилбарыг нь сонгох ёстой шүү.

Хамгийн зөв тайлбарыг нь хийх ёстой шүү гэдгийг би энд бүүр протоколд тэмдэглэж үлдээлээ.

Засгийн газар энэ дээр конвенцод нэгдэн орохдоо гэрээ хэлэлцээр байгуулахдаа анхаарна биз.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/ Санал хураалт явуулъя. Д.Цогтбаатар гишүүн үг хэлье. Д.Цогтбаатар гишүүний микрофоныг өгье.

**Д.Цогтбаатар:** Энэ чухал гэрээ, конвенцод бид нэгдэж орох процесс эцэслэн энэ элсэх процесс нь ингээд эцэслэгдэж байна гэж би ойлгож байна.

Тэгэхээр энэ дээр нэг зүйлийг манайхан тал талдаа ойлгож яриарай. Сая Сангийн яам ярьж байна.

**Депозитар** талтайгаа хэлэлцээ хийгээд байгаа юм шиг сая ярьж байна шүү.

Тийм юм байхгүй шүү. Гэрээ хадгалж байгаа талтай хэлэлцээ хийнэ гэж байхгүй.

Гэрээг гэрээнд оролцогч талуудтай л хэлэлцээр хийнэ. Субъектүүдтэйгээ л ярина гэсэн үг.

Нөгөөдөх нь секретариатын үүрэг өгөх, нарийн бичгийн дарга нарын үүрэг гүйцэтгэж байгаа бол энэ цэвэр техникийн асуудал.

Энд тайлбар хийх боломж яагаад үүсэж байгаа гэхээр Гадаад яам энэ дээрээ бас тодорхой хариулдаг байх хэрэгтэй.

Манайх “**тайлбар**” гэдэг үгээр олон улсын эрх зүйн хоёр ойлголтыг нэг үгээр хэлчхээд байгаа юм.

Нэг нь, **interpretation**. Нөгөөдөх нь, **reservation**.

Одоо энэ яригдаж байгаа бол reservation бөгөөд “зөвшөөрөгдсөн тайлбар”

Олон улсын гэрээний тухай хуулиараа аливаа конвенц өөртөө тодорхой тайлбар хийхийг зөвшөөрчихсөн бол оролцож байгаа тал элсэж орох мөчдөө тэр тайлбарыг хийх эрхтэй байдаг.

Түүнийхээ дагуу энэ тайлбараа бид хийгээд орж байгаа бөгөөд сая энэ Сангийн яамны ярьж байгаагаар нэг юманд санаа зовоод хэрэггүй.

Манай хийж байгаа тайлбар гэрээний конвенцын хэрэгжилтийн тодорхой хэмжээнд хязгаарлаж болно. Бид тэр хязгаарласан хэмжээндээ л үүргээ хүлээнэ.

Тэрийг бүхээр нь ямар нэгэн тайлбаргүй аваад хэрэглэж байгаа улс өөрт нь тэр улсдаа бол бүрэн хэрэглэгдэнэ үү гэхээс манайтай хоёр талын харилцаан дээрээ бол манай тайлбарын хүрээнд л хэрэглэнэ.

Түүнээс хэтрүүлж хэрэглэх боломжгүй. Яагаад гэвэл гэрээ гэдэг бол хоёр тал хүлээн зөвшөөрсөн хэмжээндээ хэрэгжинэ.

Манайх тодорхой хэмжээг нь хүлээн зөвшөөрөөгүй. Тэгээд хүлээн зөвшөөрөхгүй байхыг конвенц өөрөө зөвшөөрөөд өгчихсөн бол тэрнээс давуулж нөгөө тал хэрэглэх боломжгүй. Энэ конвенцыг.

Тэгэхээр та нар энэ юугаа бас гүйцэд. Энэ би бас протоколд ороосой гэж бодоод.

Дараа нь энэ reservation эд нарыг чинь хэрэглээд эхлэхээр, тайлбарыг хэрэглээд эхлэхэд энэ дээр чинь асуудал гарч болзошгүй бөгөөд энэ дээр ингэж ойлгож, хоёрдмол утгаар тайлбарлалгүйгээр бид үүнд ингэж нэгдэж орсон юм. Манай тайлбар энэ хэмжээнд энэ конвенцын үйлчлэлийг хязгаарлаж өгч байгаа юм гэдгээ их тодорхой тал талдаа ойлгож байх нь зөв байх. Баярлалаа.

**Б.Энх-Амгалан:** Д.Цогтбаатар гишүүнд баярлалаа.

Маш чухал санал хэллээ шүү. Протоколд сайн тэмдэглээрэй.

Сүүлд нь энэ гэрээний конвенцод нэгдэн орсныхоо дараа хэрэглэхдээ яг энэ зарчмыг барина шүү.

Хадгалж байгаа тал биш, зөвшилцөж байгаа хоёр тал энэ дээр асуудлаа ярих ёстой шүү гэдэг нь маш зөв тайлбар шүү.

Түрүүн хадгалж байгаа гэж орж ирсэн шүү. Та нараас.

Энэ “олон улсын гэрээний тайлбар” гэж “олон улсын гэрээ байгуулахдаа тухайн гэрээний тодорхой заалтыг Монгол Улсын хувьд хэрэгжүүлэхэд хуулийн үйлчлэлийг нь хасах, эсхүл өөрчлөх зорилгоор энэ хуульд заасны дагуу гаргасан мэдэгдлийг хэлнэ” гэсэн тодорхойлолтыг бас протоколд үлдээлээ.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна.

“Татварын суурийг багасгах тухай олон талт конвенцыг соёрхон батлах тухай” хуулийн төслийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

11 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 54.5 хувийн саналаар уг санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал,

дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар танилцуулъя.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг өндөрлөснийг мэдэгдье.

Хуралд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын эрхэм гишүүд болон ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа. Хуралдаан өндөрлөлөө. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 19 минут үргэлжилж, 12 цаг 16 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**